

Туул тосгоны хүн эмнэлэг

Туул тосгоны хүн эмнэлэг нь анх 1964 оны 08 дугаар сарын 10-анд Ажилчны районы 14 дүгээр хорооны эмнэлэг нэртэйгээр 1 их эмч, 1 сувилагчтай байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. Эмнэлгийн анхны даргаар их эмч Д.Цэндсүрэн 1964-1987 он хүртэл ажилласан бөгөөд 1987-2001 он хүртэл М.Ядмаа, 2001-2002 онд Б.Буяндэлгэр, 2003-2003 оны 10 сар хүртэл Ц.Баянбилэг, 2003 оны 10 дугаар сараас одоог хүртэл Ж.Хуяг тус эмнэлгийн даргаар ажиллаж байна.

1973 оноос эхлэн Ажилчны районы нэгдсэн эмнэлгийн харьяанд 15 ортой больниц нээн ажиллуулж, 1984 оноос биеэ даасан тосгоны эмнэлэг болон одоог хүртэл тасралтгүй үйл ажиллагаа явуулж байна.

Туул тосгоны эмнэлэг нь Улаанбаатар хотоос 37 км алслагдсан, тосгоны 682 өрхийн 3606 хүн амд эрүүл мэндийн анхан шатны болон нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэн ард олныхоо итгэлийг хүлээн ажиллаж байна.

Тус хамт олон 2005 онд ажил үйлсээрээ шалгаран "Сувилахуйн амьдрал" төвийн "Сайн үйлстэн тэргүүний хамт олон" өргөмжлөлийг хүртсэн бөгөөд хөдөлмөр бүтээлээрээ хамт олноо хошуучлан ажиллаж байгаа эмч, сувилагч, ажилчид олон бий.

Үүнд: Эрүүлийг хамгаалах яамны жуух, бичигт, нийслэлийн "Тэргүүний залуу" алтан медальт ерөнхий эмч Ж.Хуяг, нийслэлийн "Тэргүүний залуу" алтан медальт сувилагч Ш.Өнөр, нийслэлийн "Тэргүүний сувилагч" алтан медальт сувилагч Т.Нямлхагва, нийслэлийн ЭМГ-ын тэргүүний ажилтан сувилагч П.Дарьсүрэн, санхүү банкны тэргүүний ажилтан нягтлан бодогч Ц.Тунгалаг нарыг нэрлэж болно.

Туул тосгоны хүн эмнэлгийг удирдаж байсан үе үеийн дарга нарын ололт амжилтаас товчхон дурдвал

Д.Цэндсүрэн эмчийн ажиллаж байсан хугацаанд тус эмнэлгийн үйл ажиллагаа өргөжин бие даасан лабораторитой, хүүхдийн хэсэгтэй болж, улмаар 1973 оноос Ажилчны районы нэгдсэн эмнэлгийн харьяанд 15 ортой больниц нээн ажиллуулсан байна.

М.Ядмаа ерөнхий эмчээр ажиллах хугацаандаа 1984 онд Туул хорооны хүн эмнэлэг, 1992 онд Туул дүүргийн нэгдсэн эмнэлэг, 1995 оноос Туул тосгоны хүн эмнэлэг нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн.

Энэ хугацаанд хүн ардад үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж дээшилж, үйлчлүүлэгчдийн ая тухтай байдлыг хангах зорилгоор эмнэлгийн 2 давхар барилгыг иж бүрнээр нь амбулатори, больниц болгон ашиглаж, түргэн тусламжийн шинэ машинтай болжээ. Тосгоны нутаг дэвсгэрт хоггүй орчин бүрдүүлэх талаар тус эмнэлэг нь идэвх санаачлагатай ажиллаж байв.

2003 оны 10 дугаар сараас одоог хүртэл Ж.Хуяг ерөнхий эмчээр ажиллаж байгаа бөгөөд энэ хугацаанд тус эмнэлгийн материаллаг бааз бэхжин, тосгоны иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний чанар, хүртээмж, жилээс жилд сайжирч, боловсон хүчний мэргэжил ур чадвар дээшлэн стандартын дагуу бүрэн орон тоотойгоор ажиллаж байна. Үүнд: их эмч 4, статистикт бага эмч 1, сувилагч 5, асрагч 4, лаборант 1, нягтлан бодогч, нярав, тогооч, жолооч, угаагч, слесарь, архив бичиг хэргийн

ажилтан тус бүр 1 бүгд 22 орон тоотойгоор амбулатори, стационарт, дотор эмийн сан, аж ахуйн хэсэг гэсэн 4 тасаг нэгж, 15 ортой үйл ажиллагаа явуулж байна.

Эмнэлгийн материаллаг баз бэхжин 2004-2008 онуудад нэн шаардлагатай тоног төхөөрөмжүүдээр бүрэн хангагдлаа

ҮҮНД: Зөөврийн автоклав, мэс заслын иж бүрдэл, отсосын аппарат, угаалгын аппарат, сольюкс, сувилагчийн ширээ, автлмакс, гемоглобиномер, центрифуг, сушильный шкаф, ЭКГ аппарат, ЭХО аппарат, хөлдөөгч, тэргэнцэр иж бүрэн компьютер принтерийн хамт 2ш, глюкометр, биохимийн хагас автомат анализатор, зэрэг техник тоног төхөөрөмжүүдийг өөрийн хөрөнгө болон хандив тусламжаар бэлтгэж, мөн парк ашиглалтаа шинэчлэн 2008 оны эхний хагаст жилд Аксент маркийн түргэн тусламжийн машин 1-ийг шинээр авлаа. Хэвтэн эмчлүүлэгчдийн ая тухтай байдлыг хангах зорилгоор палатуудыг тохижуулан ор хөнжлийн даавуу, гудас зэргийг нэг оронд 9 ээлжийн болгож бэлдсэн. Дэлхийн зөн олон улсын байгууллагатай хамтран ажиллаж иргэдийн дунд сургалт сурталчилгааг тогтмол хийж хэвшсэн.

Дүгнэлт: Нийслэлийн хүн ам жилээс жилд өсөн нэмэгдэж хот, захруугаа тэлэх халдлагатайн дээр тосгоны хүн ам өсөн нэмэгдэхийн хирээр иргэдэд үзүүлэх нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээ шаардагдаж байгаа учир сумын эмнэлгийн 2-3 дугаар шатлалд шилжин ажиллах шаардлага тавигдаж байгаа.